



САНГИЙН ЯАМ

2022

**Монгол Улсын 2022 оны
эхний хагас жилийн эдийн
засаг, төсвийн тойм**



Монгол Улсын Сангийн яамны санаачилгаар, Европын холбооны буцалтгүй тусламжаар Дэлхийн банкны хэрэгжүүлж буй Монгол Улсад засаглалын бэхжүүлэх төслийн хүрээнд энэхүү тоймыг бэлтгэн гаргав.

АГУУЛГА

ХҮСНЭГТ	3
ЗУРАГ	3
I. Макро эдийн засгийн хагас жилийн тойм	4
Эдийн засгийн өсөлт.....	4
Үйлдвэрлэлийн аргаар тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүн.....	4
Эцсийн ашиглалтын аргаар тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүн.....	5
Гадаад худалдаа.....	6
Төлбөрийн тэнцэл.....	7
Инфляц.....	8
II. 2022 оны нэгдсэн төсвийн хагас жилийн гүйцэтгэл	10
Төсвийн орлого.....	12
Төсвийн зарлага.....	16
Нийгмийн даатгалын сангийн төсөв.....	19
Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв.....	20
Улсын төсвийн хөрөнгө оруулалт.....	21
Гадаад зээл, тусламжийн ашиглалт.....	22
Засгийн газрын өр.....	24
Засгийн газрын дотоод үнэт цаас.....	25
Засгийн газрын гадаад үнэт цаас.....	25
Засгийн газрын гадаад зээл.....	26
Барих-шилжүүлэх концесс.....	26
III. Макро эдийн засаг, төсвийн төсөөлөл	27
Эдийн засгийн өсөлт.....	27
Гадаад худалдаа.....	27
Инфляц.....	27
Төсвийн орлого.....	28
Төсвийн зарлага.....	28
Засгийн газрын өрийн төсөөлөл.....	29

ХҮСНЭГТ

ХҮСНЭГТ 1. ДНБ, 2022 оны эхний хагас жилд.....	4
ХҮСНЭГТ 2. Эдийн засгийн өсөлт, салбаруудаар.....	4
ХҮСНЭГТ 3. ДНБ зэрэгцүүлэх үнээр, өөрчлөлт эхний улирлаар	5
ХҮСНЭГТ 4. Хагас жилийн экспорт, импортын гүйцэтгэл	6
ХҮСНЭГТ 5. Төлбөрийн тэнцэл, хагас жилийн урьдчилсан гүйцэтгэл.....	7
ХҮСНЭГТ 6.Инфляцад импортын барааны үнийн өсөлтийн оролцоо.....	8
ХҮСНЭГТ 7.Улсын нэгдсэн төсвийн үзүүлэлт, тодотголын дараах дүн	10
ХҮСНЭГТ 8. Улсын нэгдсэн төсвийн үзүүлэлт, хагас жилийн гүйцэтгэл.....	11
ХҮСНЭГТ 9.Улсын нэгдсэн төсвийн алдагдлын санхуужилт, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар.....	11
ХҮСНЭГТ 10.Улсын нэгдсэн төсвийн орлого, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар ..	13
ХҮСНЭГТ 11.Эрдэс бүтээгдэхүүний экспортын төлөвлөгөө, гүйцэтгэл (биет хэмжээгээр).....	15
ХҮСНЭГТ 12.Улсын төсөвт төвлөрүүлсэн орлого.....	15
ХҮСНЭГТ 13.Улсын нэгдсэн төсвийн зарлага, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар	17
ХҮСНЭГТ 14. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар.....	19
ХҮСНЭГТ 15.Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлага, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар.....	20
ХҮСНЭГТ 16.Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хагас жилийн гүйцэтгэл	21
ХҮСНЭГТ 17.Гадаад зээл, тусламжийн хүлээгдэж буй гүйцэтгэл.....	22
ХҮСНЭГТ 18.Гадаад зээл, тусламж хөгжлийн түншээр	23
ХҮСНЭГТ 19. Засгийн газрын өрийн бүтэц, тэрбум төгрөг	24

ХҮСНЭГТ 20. Макро эдийн засаг болон улсын төсвийн үзүүлэлтүүд	29
---	----

ЗУРАГ

ЗУРАГ 1. ДНБ өсөлт бууралт, хувиар	4
ЗУРАГ 2. Эдийн засгийн өсөлт, бууралт салбараар	5
ЗУРАГ 3. Хагас жилийн экспорт, импорт, тэнцэл.....	6
ЗУРАГ 4. Экспорт, импорт түнш орнуудаар, %	7
ЗУРАГ 5. Инфляцын түвшин, сүүлийн нэг жилээр	8
ЗУРАГ 6. Улсын төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл.....	11
ЗУРАГ 7. Татварын орлогын бүтэц, хувиар.....	14
ЗУРАГ 8. Урсгал зардлын бүтэц, хувиар.....	18
ЗУРАГ 9. Монгол Улсын Засгийн газрын өр, тэрбум.төг	24
ЗУРАГ 10. Монгол Улсын Засгийн газрын өр, тэрбум.төг	25
ЗУРАГ 11. Гадаад үнэт цаасны хүү.....	25
ЗУРАГ 12. Гадаад зээл	26
ЗУРАГ 13. Барих-шилжүүлэх төрлийн концессын үлдэгдэл	26

I. Макро эдийн засгийн хагас жилийн тойм

Эдийн засгийн өсөлт

Үйлдвэрлэлийн аргаар тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүн

2022 оны эхний хагас жилд Үйлдвэрлэлийн аргаар тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүн **23.0** их наяд төгрөгт хүрч, эдийн засаг өмнөх оны хагас жилээс **1.9%-р** өссөн үзүүлэлттэй байна.

Эдийн засгийн бодит өсөлтийг салбараар авч үзвэл хөдөө аж ахуйн салбар 11.3 хувиар, бөөний болон жижиглэн худалдааны салбар 12.2 хувиар, үйлчилгээний салбар 4.6 хувиар тэлсэн нь нийт өсөлтийг дэмжсэн бол уул уурхай салбар 28.8 хувиар, барилгын салбар 8.7 хувиар, тээврийн салбар 22.5 хувиар тус тус буурсан нь нийт өсөлтийг хязгаарласан байна.


Дэлхийн зах зээл дээрх уул, уурхайн эрдэс бүтээгдэхүүний үнэ өсөж, эрэлт тогтвортой байгаа хэдий ч КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр хилийн боомтуудын үйл ажиллагаа саатсан хэвээр байгаа нь түүхий эдийн экспорт, уул уурхайн салбарын үйл ажиллагааг бууруулж, эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлж байна. Тухайлбал, энэ оны эхний хагас жилийн байдлаар зэсийн баяжмал өмнөх оны мөн үеэс 16.3 хувиар, нүүрсний олборлолт 45 хувиар, газрын тосны олборлолт 97.5 хувиар тус тус буураад байна.

ХҮСНЭГТ 1. ДНБ, 2022 оны эхний хагас жилд

/их наяд.төг/	2019	2020	2021	2022
ДНБ, оны үнээр	17.9	17.0	19.9	23.0
ДНБ, 2015 оны з.үнээр	13.0	11.8	12.6	12.8

Эх үүсвэр: УСХ

ЗУРАГ 1. ДНБ өсөлт бууралт, хувиар




ХҮСНЭГТ 2. Эдийн засгийн өсөлт, салбаруудаар

/тэрбум.төг/	2015 оны зэрэгцүүлэх үнээр					Оролцоо /хувь/
	2018.I	2019.I	2020.I	2021.I	2022.I	
ДНБ	12,062.1	12,973.0	11,811.0	12,554.4	12,791.0	1.9%
Хөдөө аж ахуй	1,794.7	1,830.5	2,057.4	1,963.2	2,185.8	1.8%
Уул уурхай	1,700.5	1,907.4	1,306.5	1,613.9	1,149.2	-3.7%
Аж үйлдвэр барилга	1,384.5	1,452.9	1,407.9	1,417.3	1,400.1	-0.1%
Боловсруулах үйлдвэрлэл	781.4	790.6	743.9	831.8	813.8	-0.1%
Цахилгаан	318.7	333.7	341.2	372.7	392.0	0.2%
Барилга	284.3	328.7	322.8	212.9	194.3	-0.1%
Үйлчилгээ	5,609.7	6,071.9	5,541.8	5,710.7	5,988.0	2.2%
Худалдаа	1,181.5	1,370.6	1,164.3	1,224.9	1,374.7	1.2%
Тээвэр, агуулах	500.3	531.8	360.6	397.2	307.8	-0.7%
Мэдээлэл, холбоо	247.2	286.3	302.0	361.2	406.3	0.4%
Бусад үйл ажиллагаа	3,680.8	3,883.2	3,715.0	3,727.5	3,899.1	1.4%
Цэвэр татвар	1,572.8	1,710.4	1,497.5	1,849.3	2,067.9	1.7%

Хөдөө аж ахуйн салбар 2022 оны эхний хагас жилд 11.3 хувиар өсөхөд том малын зүй бус хорогдол буурсан нь голлон нөлөөлжээ.

2021 оны эхний хагас жилд Говь-Алтай, Дундговь, Өвөрхангай, Баянхонгор, Өмнөговь зэрэг аймгуудад хаваржилт хүндэрсний улмаас том малын зүй бус хорогдол 2.4 саяд хүрээд байсан бол 2022 оны эхний хагас жилд 218.1 мянга болж, өмнөх оноос 90.9 хувиар буурсан нь ДНБ-д 1.8 нэгж хувиар эерэг нөлөө үзүүлсэн.

ЗУРАГ 2. Эдийн засгийн өсөлт, бууралт салбараар



Уул уурхайн олборлолтын салбарын нэмэгдэл өртөг буурахад экспортын бууралттай холбоотой нүүрс олборлолт 42.8 хувь, газрын тос олборлолт 95.0 хувь тус тус буурсан нь ДНБ-д 3.7 нэгж хувиар сөрөг нөлөө үзүүлэв.

Өмнөх оноос эхлэн цар тахлын эсрэг вакцинжуулалт амжилттай хийгдэж, дотоодын эдийн засаг, бизнесийн үйл ажиллагаанд аливаа хязгаарлалт байхгүй байгаа нь дотоодын эдийн засгийн идэвхжилийг нэмэгдүүлж, худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарыг өсөхөд нөлөөлсөн байна.

Бүтээгдэхүүний цэвэр татварын хэмжээ ДНБ-д 1.7 хувийн эерэг нөлөө үзүүлсэн ба үүнд нэмэгдсэн өртгийн албан татвар 34.1 хувь, онцгой болон гадаад худалдааны татвар 25.2 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүн

Эдийн засгийн өсөлтийг эрэлт талаас тайлбарлахад эцсийн хэрэглээ 2022 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 3.7 нэгж хувиар, хөрөнгийн нийт хуримтлал 8.5 нэгж хувиар нэмэгдсэн нь өсөлтийг дэмжсэн бол БНХАУ-ын “0 Ковид” стратегитай холбогдуулан хилийн хорио цээр чангаруулсны улмаас экспортын биет хэмжээ огцом саарсан нь өсөлтийг хязгаарлах хүчин зүйл болсон байна.

ХҮСНЭГТ 3. ДНБ зэрэгцүүлэх үнээр, өөрчлөлт эхний улирлаар

/тэрбум төгрөг/	2015 оны зэрэгцүүлэх үнээр					Оролцоо /хувь/
	2018.I	2019.I	2020.I	2021.I	2022.I	
ДНБ	11,873.9	12,793.5	11,831.6	12,562.5	12,804.6	1.9%
Эцсийн хэрэглээ	10,124.6	10,718.1	11,471.2	10,446.9	11,114.3	5.3%
Өрхийн хэрэглээ	8,236.2	8,619.5	9,166.3	8,320.6	8,897.5	4.6%
Төрийн хэрэглээ	1,888.4	2,098.5	2,304.9	2,126.3	2,216.8	0.7%
Хөрөнгийн хуримтлал	4,198.6	4,422.4	3,308.5	4,786.6	6,857.9	16.5%
ҮХ-н нийт хуримтлал	3,192.2	3,838.2	3,043.3	3,426.3	4,734.6	10.4%
МЭХ-н өөрчлөлт	1,006.5	584.3	265.2	1,360.4	2,123.4	6.1%
БҮЦ экспорт	(2,449.3)	(2,347.0)	(2,948.1)	(2,671.1)	(5,167.6)	-19.9%

БҮ-ний экспорт	6,603.1	6,994.1	5,120.4	5,836.3	4,900.1	-7.5%
БҮ-ний импорт (-)	9,052.4	9,341.1	8,068.5	8,507.3	10,067.6	12.4%

-Өрхийн хэрэглээний дүнд өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээг оруулсан.

-Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлтийн дүнд үнэт зүйлсийн хуримтлал, статистик зөрүү орсон.

Эх үүсвэр: YCX

Эцсийн хэрэглээ ДНБ-ий өсөлтөд **5.3** хувийн эерэг нөлөө үзүүлэхэд өрхийн эцсийн хэрэглээ 2022 оны эхний хагас жилд 8.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 6.9 хувиар өссөн, төрийн байгууллагын хэрэглээ 2022 оны эхний хагас жилд 2.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 4.3 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

Мөн хөрөнгийн хуримтлал **16.5** хувийн эерэг оролцоо нь үндсэн хөрөнгийн нийт хуримтлал өмнөх оны мөн үеэс 38.2 хувиар, материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт өмнөх оны мөн үеэс 56.1 хувиар тус тус өссөнтэй холбоотой байна.


Гадаад эдийн засгаас хүлээн авсан цэвэр орлого 2022 оны эхний хагас жилд -3.6 их наяд төгрөг, хоёрдогч орлого буюу цэвэр шилжүүлэг 0.7 их наяд төгрөгт хүрснээр Үндэсний нийт орлого 19.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 12.0 хувиар өслөө.

Гадаад худалдаа

Монгол Улс 2022 оны эхний хагас жилд нийт 145 улстай худалдаа хийж, экспорт **5.3** тэрбум америк доллар, импорт **3.9** тэрбум америк долларт хүрэв.

Гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ **9.3** тэрбум америк долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 26.0%-р өсөж, худалдааны тэнцлийн ашиг өнгөрсөн оны мөн үеэс 510 сая ам.доллараар өсөж, 1.4 тэрбум ам.долларт хүрлээ.

ЗУРАГ 3. Хагас жилийн экспорт, импорт, тэнцэл



ХҮСНЭГТ 4. Хагас жилийн экспорт, импортын гүйцэтгэл


/ сая ам.доллар/	2019 I-VI	2020 I-VI	2021 I-VI	2022 I-VI	Өөрчлөлт I-VI 2021/2022
Эргэлт	6,832.8	5,288.3	7,347.6	9,256.4	26.0%
Экспорт	3,939.0	2,828.2	4,086.5	5,308.3	29.9%
Эрдэс бүтээгдэхүүн	3,307.5	2,020.6	3,389.4	4,437.1	30.9%
Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	30.7	8.0	45.1	2.1	-95.3%
Ургамлын гаралтай бүт	4.2	4.5	86.9	2.9	-96.7%
Нэхмэл бүтээгдэхүүн	271.6	118.4	223.3	264.3	18.4%
Үнэт чулуу, металл	196.3	607.1	221.3	517.2	133.7%
Импорт	2,893.8	2,460.1	3,261.1	3,948.1	21.1%
Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	202.1	197.7	278.9	366.3	31.3%
Эрдэс бүтээгдэхүүн	621.9	485.4	551.9	877.5	59.0%

Үндсэн төмөрлөг	267.1	235.6	247.1	424.8	71.9%
Тээврийн хэрэгсэл, сэлбэг	587.3	374.1	708.7	621.6	-12.3%
Хими, химийн үйлдвэр бүт	165.4	173	270.5	274.7	1.6%
Хуванцар, каучук	122.7	100.7	116.9	162.5	39.0%
Машин, механик төхөөрөмж	583.4	526.4	576.6	604.6	4.9%
Тэнцэл	1,045.2	368.0	825.4	1,360.2	64.8%

Эх үүсвэр: ҮСХ

ЗУРАГ 4. Экспорт, импорт түнш орнуудаар, %

Нийт экспортын 93 хувийг уул уурхайн бүтээгдэхүүн (чулуун нүүрс 44%, зэс 30%), 5 хувийг мал аж ахуйн бүтээгдэхүүн, 2 хувийг аж үйлдвэрийн бүтээгдэхүүн эзэлж байна.



Уул уурхайн экспорт 2022 оны эхний хагас жилд тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 1.4 тэрбум ам.доллараар буурч, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 2.7 тэрбум ам.доллараар өссөн байна.

Нийт импорт 2022 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 21 хувиар өсөхөд хэрэглээний бүтээгдэхүүний импорт 9 нэгж хувиар, нефтийн бүтээгдэхүүний импорт 9 нэгж хувиар өссөн нь голлон нөлөөлөв.

Худалдааны түнш орон, бараагаар харвал ОХУ-аас импортолсон барааны **58.9** хувийг нефтийн бүтээгдэхүүн, Япон Улсаас импортолсон барааны **68.9** хувийг суудлын автомашин, БНХАУ-аас импортолсон барааны **4.8** хувийг цахилгаан эрчим хүч, **8.5** хувийг ачааны тэрэг, **86.7** хувийг олон нэр төрлийн бага жинтэй, бараа бүтээгдэхүүн эзэлж байна.

Төлбөрийн тэнцэл

Төлбөрийн тэнцлийн урсгал данс 2022 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр 2.0 тэрбум америк долларын алдагдалтай гарч, алдагдал өмнөх оны мөн үеэс **890** (82%) **сая америк доллар**оор өсжээ. Уг өсөлтөд бараа ба үйлчилгээний худалдааны алдагдал өмнөх оны мөн үеэс 866.3 сая америк доллароор, анхдагч орлогын алдагдал 66.8 сая америк доллароор өссөн нь голлон нөлөөлсөн байна. Харин санхүүгийн тэнцэл 2022 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 104 сая америк доллароор өсөж, 0.8 тэрбум америк доллар болжээ.

ХҮСНЭГТ 5. Төлбөрийн тэнцэл, хагас жилийн урьдчилсан гүйцэтгэл

/сая ам.доллар/	2019 I-VI	2020 I-VI	2021 I-VI	2022 I-VI	Өөрчлөлт 2021/2022
Урсгал данс	-743.4	-882.7	-1,087.9	-1,978.0	82%
Бараа ба үйлчилгээний худалдаа	-149.4	-565.2	-417.6	-1,284.5	208%
Анхдагч орлого	-713.7	-445.8	-880.4	-947.2	8%
Хоёрдогч орлого	119.6	128.3	210.1	253.6	21%
Хөрөнгийн данс	57.3	51.2	49.2	87.1	77%


Урсгал болон Хөрөнгийн дансны тэнцэл	-686.1	-831.5	-1,038.8	-1,890.9	82%
Санхүүгийн данс	-1,098.4	-419.2	-690.8	-794.3	15%
Шууд хөрөнгө оруулалт	-1,053.9	-924.2	-920.2	-957.4	4%
Багцын хөрөнгө оруулалт"	-360.3	527.7	61.5	93.0	51%
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	2.1	-2.5	-1.8	-23.6	1209%
Бусад хөрөнгө оруулалт	313.8	-20.3	169.6	93.6	-45%
Алдаа болон орхигдуулга	43.7	-266.9	293.8	38.7	-87%
Төлбөрийн тэнцлийн нийт дүн	456.0	-679.2	-54.2	-1,058.0	1851%

Эх үүсвэр: Монголбанк

2022 онд дэлхий дахинд хүнс, эрчим хүчний үнэ түүхэн түвшинд хүрч нэмэгдсэн нь төлбөрийн тэнцэл, импортын өсөлтийг тайлбарлаж байгаа ба Монгол Улсын Засгийн газраас гол нэр төрлийн бүтээгдэхүүний хомстол үүсэх, үнийн огцом өсөлтөөс урьдчилан сэргийлэх үүднээс худалдааны түнш орнуудтай гэрээ хэлцэл хийх, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, нөөц бүрдүүлэх Засгийн газрын баталгаа гаргах зэрэг арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлж байна.

Инфляц

ЗУРАГ 5. Инфляцын түвшин, сүүлийн нэг жилээр



2022 онд Монголбанкны инфляцын зорилтот түвшин **6±2** боловч 2022 оны эхний хагас жилд Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ Улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс **16.1** хувь, өмнөх оны эцсээс **9.5** хувь, өмнөх сараас **1.5** хувиар өссөн байна.

Инфляцын өсөлтөд хүнсний бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, тээвэр, логистикийн саатал, тээврийн зардлын өсөлт, худалдааны түнш орнуудын инфляц нэмэгдсэн хүчин зүйлс голлон нөлөөлсөн байна.

Инфляц 2022 оны 6 дугаар сард **16.1** нэгж хувь гарсны **57.1** хувь буюу **9.2** нэгж хувь нь импортын барааны үнийн өсөлтөөс шалтгаалсан байна. Импортын барааны үнийн өсөлтийн нөлөөлөл нь өмнөх оны мөн үеэс **19.2** нэгж хувь, өмнөх сараас **0.8** нэгж хувиар нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 6. Инфляцад импортын барааны үнийн өсөлтийн оролцоо

		2019 VI	2020 VI	2021 VI	2022 VI
Ерөнхий индекс	Нэгж хувь	8.3	2.8	6.6	16.1
	Хувь	100	100	100	100
Импортын барааны нөлөө	Нэгж хувь	2.9	0.5	2.5	9.2
	Хувь	34.9	17.9	37.9	57.1

Эх үүсвэр: YCX

Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсанд нийт 373 нэр төрлийн бараа, үйлчилгээ, Улаанбаатар хотын хэмжээнд 344 нэр төрлийн бараа, үйлчилгээний үнийг судалдаг. Нийт 373 нэр төрлийн бараа, үйлчилгээний 200 нь импортын бараа байгаа бөгөөд энэ нь нийт жингийн **45.5** хувийг эзэлж байна.

II. 2022 оны нэгдсэн төсвийн хагас жилийн гүйцэтгэл

Төсвийн тодотгол

2022 онд Монгол улсын засгийн газар 2 удаа төсвийн тодотгол хийгээд байна. УИХ-с 2022 оны 1-р сарын 31-ний өдөр баталсан Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар төсөвт байгууллагуудын цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжээс бусад бүх урсгал зардлыг дунджаар 15.4 хувиар бууруулж, ахмад настны тэтгэвэр тэтгэмжийг нэмэгдүүлэх боломжийг бий болгосон.

Дэлхий нийт кроновирусын халдварын эсрэг вакцинжуулалтыг амжилттай хийж, халдварын тархалт буурснаар 2022 онд дэлхийн болон Монгол улсын эдийн засаг сэргэж, цар тахлын өмнөх эдийн засгийн идэвхжилийн түвшинд эргэн хүрнэ гэсэн эерэг хүлээлттэй байсан боловч энэ оны 2-р сард Оросын Холбооны Улс болон Украин Улс хооронд үүссэн нөхцөл байдал олон улсын геополитик, эдийн засагт урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлыг үүсгэсэн. Мөн цар тахлын хэмжээ буурахгүй байгаа нь олон улсын эдийн засгийн байдлыг улам хүндрүүлж буй зэрэг гадаад хүчин зүйлийн улмаас засгийн газар төсөв мөнгөний бодлогод нөлөөлж байгаа эрсдэлийг бууруулах чиглэсэн богино хугацааны стратеги буюу төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсөв хоорондын зохицуулалт хийх төсвийн 2 дахь удаагийн тодотголыг 2022 оны 4-р сарын 20-ны өдөр УИХ-д өргөн барьж, 4-р сарын 29-ний өдөр УИХ хэлэлцэн баталсан.

ХҮСНЭГТ 7. Улсын нэгдсэн төсвийн үзүүлэлт, тодотголын дараах дүн

/тэрбум.төг/	2022 Бат	2022 Тод I	Зөрүү	2022 Тод-II	Зөрүү
Нийт орлого	16,415.1	16,415.1	-	16,278.10	-136.9
Тогтворжуулалтын сан	643.4	643.4	-	751.7	108.3
Тэнцвэржүүлсэн орлого (I)	15,771.7	15,771.7	-	15,526.40	-245.3
Нийт зардал (II)	18,158.8	18,158.8	-	17,913.50	-245.3
Урсгал зардал	13,226.3	13,516.6	-290.4	13,897.80	284.0
Хөрөнгийн зардал	5,197.1	4,906.7	290.4	4,280.30	-529.3
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-264.6	-264.6	-	-264.6	-
Тэнцвэржүүлсэн тэнцэл (I-II)	-2,387.1	-2,387.1	-	-2,387.1	-
ДНБ-д эзлэх хувь	-5.1%	-5.1%		-5.1%	

Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2022 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр **8.0** их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс **895.4** (12.6%) тэрбум төгрөг, тэнцвэржүүлсэн орлого тусламжийн хэмжээ **7.3** их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс **919.2** (14.3%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 8. Улсын нэгдсэн төсвийн үзүүлэлт, хагас жилийн гүйцэтгэл

/тэрбум.төг/	2019 I-VI	2020 I-VI	2021 I-VI	2022 I-VI		2022 ХБГ
Нийт орлого	5,548.8	4,358.7	7,106.1	8,001.5	49%	16,278.1
Ирээдүй өв сан	616.6	246.5	417.7	-	-	-
Тогтворжуулалтын сан	31.8	12.0	259.7	653.6	87%	751.7
Тэнцвэржүүлсэн орлого (I)	4,900.4	4,100.3	6,428.7	7,347.9	47%	15,526.4
Нийт зардал (II)	4,708.3	6,298.3	7,498.2	8,191.9	46%	17,913.5
Урсгал зардал	3,962.3	5,050.8	6,559.6	7,004.8	50%	13,897.8
Хөрөнгийн зардал	636.1	1,228.9	859.6	1,158.9	27%	4,280.3
Эргэж төлөгдөх цэвэр зээл	109.9	18.7	78.9	28.2	-11%	-264.6
Тэнцвэржүүлсэн тэнцэл (I-II)	192.2	-2,198.0	-1,069.5	-844.0	35%	-2,387.1

ЗУРАГ 6. Улсын төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл



Нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2022 оны эхний хагас жилд **8.2** их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн тэнцэл **844.0** тэрбум төгрөгийн алдагдалтай гарчээ.

ХҮСНЭГТ 9. Улсын нэгдсэн төсвийн алдагдлын санхүүжилт, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар

Эх үүсвэр /тэрбум.төг/	2019 I-VI	2020 I-VI	2021 I-VI	2022 I-VI	2022 I-VI 2021 I-VI
АЛДАГДЛЫН САНХҮҮЖИЛТ	-192.2	2198.0	1069.5	844.0	78.9%
Харилцах болон хадгаламжийн дансны өөрчлөлт	-359.9	1079.4	1310.4	704.7	53.8%
Засгийн газрын бонд	-78.9	-62.1	-468.3	-125.5	26.8%
Засгийн газрын зээл	246.4	1159.9	227.1	263.8	116.2%
Дотоод	0.0	-44.1	0.0	0.0	-
Гадаад	246.4	1204.0	227.1	263.8	116.2%
Өмч хувьчлал	0.2	20.8	0.3	1.0	3.7 ¹

¹ -дахин их

Төсвийн орлого

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2022 оны эхний 6 сарын байдлаар **8,001.5** тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн хэмжээнээс **71.8** тэрбум төгрөгөөр дутуу биелэлттэй байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад **895.4** тэрбум төгрөг буюу **13** хувиар өссөн үзүүлэлт юм. Харин 2022 оны хүлээгдэж буй гүйцэтгэл тодотголын түвшинд байхаар байна.

Төсвийн орлогын эрсдэл

- Коронавируст халдварын цар тахлын тодорхой бус нөхцөл байдал нь төсвийн орлогын биелэлтэд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй байна.
- Нүүрс, газрын тосны бүтээгдэхүүний гол худалдан авагч болох БНХАУ-д коронавируст халдварын цар тахлын дотоодын халдвар дахин нэмэгдэж, тус улсын Засгийн газар “Тэг-КОВИД” бодлого хэрэгжүүлэн, зарим бүсэд хатуу хөл хорио тогтоож, хилийн боомтууд дээр хязгаарлалт тавьж байгаа нь манай улсын экспортын бүтээгдэхүүний хэмжээ буурахад нөлөөлж байна.
- Түүнчлэн, ОХУ-Украин улс хоорондын зэвсэгт мөргөлдөөн эхэлснээр дэлхийн улс төр, эдийн засагт урьдчилан тооцох боломжгүй, тодорхойгүй, хүндрэлтэй нөхцөл байдлыг бий болгон, эрчим хүч, нефтийн үнэ, хүнсний бүтээгдэхүүний үнээр дамжуулан манай улсын эдийн засагт ч мөн адил сөргөөр нөлөөлж болзошгүй байна.
- Томоохон эдийн засагтай улс орнуудын төв банкууд инфляцын өсөлтийг хазаарлах үүднээс бодлогын хүүгээ чангаруулах бодлого баримтлах болсноос үүдэлтэй зэсийн үнийн бууралт орлогын гүйцэтгэлд сөргөөр нөлөөлөх төлөвтэй байна.

ЗГ-с авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

- Төсвийн орлогод учирч буй эрсдэлийг бууруулах, төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангах зорилгоор Засгийн газраас Гашуунсухайт-Ганцмод боомтоор нэвтрэх машины тоог нэмэгдүүлэх, Шивээхүрэн-Сэхээ боомтыг ойрын хугацаанд нээн, үйл ажиллагааг хэвийн горимд шилжүүлэх ажлыг зохион байгуулж, нүүрсний экспортын хэмжээг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч байна.
- Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглал, ил тод байдлыг сайжруулах, ашигт ажиллагааг дээшлүүлэх, үр ашиггүй, өгөөж багатай хөрөнгө оруулалт, зардлыг бууруулах, хэмнэх ажлыг өргөн хүрээнд зохион байгуулж, төрийн өмчийн хөрөнгийн төрд ногдох өгөөж, төсөвт төвлөрүүлэх татвар, ногдол ашиг болон бусад орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ
- Татвар, гаалийн бүртгэлийг сайжруулах замаар татварын хамрагдалтыг нэмэгдүүлэх, далд эдийн засгийг бууруулах ажлыг үргэлжлүүлж, орлогын боломжит эх үүсвэрийг бүрэн дайчилна.


ХҮСНЭГТ 10. Улсын нэгдсэн төсвийн орлого, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар

Орлогын төрөл /тэрбум.төг/	2019 I-VI	2020 I-VI	2021 I-VI	2022* I-VI	2022* 2021
НИЙТ ОРЛОГО	5548.8	4358.7	7106.1	8001.5	112.6
ИРЭЭДҮЙН ӨВ САН	616.6	246.5	417.7	0.0	-
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	31.8	12.0	259.7	653.6	2.5 ¹
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО	4900.4	4100.3	6428.7	7347.9	114.3
ТАТВАРЫН ОРЛОГО	4446.2	3742.9	5588.4	6940.7	124.2
Орлогын албан татвар	1142.5	919.6	1848.2	1552.7	84.0
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	751.8	537.4	1356.2	988.6	72.9
Хувь хүний орлогын албан татвар	425.7	415.1	523.7	612.1	116.9
Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогын татвар	299.4	302.6	375.7	458.7	122.1
Үйл ажиллагааны орлогын	20.6	20.8	26.6	33.6	126.3
Хөрөнгийн орлого	54.0	56.2	69.7	45.7	65.6
Хөрөнгө борлуулсны орлогын	3.2	4.7	26.7	30.4	113.6
Шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих, шинэ бүтээл, бүтээгдэхүүн	0.0	0.0	0.0	0.0	-
Урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал	0.4	0.4	0.2	0.1	71.7
Шууд бус орлого	48.0	30.3	24.8	43.6	175.9
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-35.0	-33.0	-31.7	-48.0	151.4
Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татвар	0.0	0.0	0.0	0.0	6.6
Нийгмийн даатгалын орлого	924.6	786.1	994.5	1386.4	139.4
Хөрөнгийн албан татвар	88.0	79.6	94.7	123.6	130.6
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	54.1	46.2	56.1	75.5	134.7
Бууны албан татвар	0.6	0.4	0.5	0.5	106.8
Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн татвар	33.4	33.1	37.8	42.4	112.2
Нэмэгдсэн өртгийн албан татвар	1050.5	953.6	1345.8	1804.7	134.1
Дотоодын бараа, үйлчилгээний	473.8	452.0	601.4	773.6	128.6
Импортын барааны	757.4	700.6	883.0	1197.4	135.6
НӨАТ-ын буцаан олголт	-180.7	-199.0	-138.6	-166.3	120.0
Онцгой албан татвар	427.1	365.2	396.1	466.0	117.6
Дотоодын архи, дарсны	97.0	74.5	79.7	121.7	152.7
Дотоодын тамхины	16.4	11.5	12.1	15.0	123.4
Дотоодын шар айрагны	12.7	10.9	17.1	20.2	118.2
Импортын архи, дарсны	3.8	3.8	8.3	12.1	144.7
Импортын тамхины	49.5	53.1	64.4	68.8	106.8
Импортын шар айрагны	0.8	1.0	2.1	2.4	112.7
Суудлын автомашины	129.9	89.5	94.9	144.0	151.6
Автобензин, дизелийн түлшний	117.1	121.0	117.4	81.9	69.7
Тусгай зориулалтын орлого	7.5	8.0	6.5	9.4	144.7
Автобензин, дизелийн түлшний татвар	7.5	8.0	6.5	9.4	144.7
Гадаад үйл ажиллагааны орлого	362.9	335.8	441.4	582.7	132.0
Импортын барааны гаалийн албан татвар	362.9	335.8	441.3	582.7	132.0
Экспортын гаалийн албан татвар	0.0	0.0	0.0	0.0	21.7
Бусад татвар, төлбөр, хураамж	443.0	294.8	461.3	1015.3	2.2 ¹
Нийтлэг бусад төлбөр, хураамж	366.6	220.1	365.0	886.1	2.4 ¹
Улсын тэмдэгтийн хураамж	24.3	20.8	59.4	23.7	39.8

Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	16.3	14.6	14.6	15.1	103.7
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	250.9	132.5	226.3	804.2	3.6 ¹
Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	3.0	3.7	0.4	0.6	149.4
Агаарын бохирдлын төлбөр	27.3	16.5	30.7	10.2	33.3
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	7.8	8.8	8.9	10.0	112.9
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1.1	0.9	1.1	1.6	144.4
Ус бохирдуулсны төлбөр	0.0	0.0	0.2	1.5	9.7 ¹
Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж	0.0	0.0	0.0	0.0	7.6 ¹
Бусад төлбөр, хураамж	35.7	22.3	23.4	19.1	81.7
Газрын төлбөр	49.0	50.5	64.2	96.3	150.0
Байгалын нөөц ашигласны төлбөр	24.1	21.9	29.5	27.6	93.4
Ойн нөөц ашигласны төлбөр	1.4	1.7	6.6	2.6	40.4
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	1.3	0.3	0.3	0.7	2.6 ¹
Ус рашааны нөөц ашигласны төлбөр	21.5	19.9	21.9	24.2	110.6
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	0.0	0.1	0.9	0.1	10.8
Бусад татвар	3.3	2.3	2.5	5.2	2.1 ¹
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	454.3	357.4	840.3	407.2	48.5
Нийтлэг татварын бус орлого	436.4	345.7	798.6	330.1	41.3
Хувьцааны ногдол ашиг	1.0	2.2	14.5	9.0	61.8
Хүүгийн орлого	22.2	36.3	27.1	19.7	72.9
Торгуулийн орлого	36.2	34.0	40.2	52.7	131.3
Төсөвт байгууллагын өөрийн орлого	135.8	143.2	177.0	165.9	93.7
Түрээсийн орлого	1.1	2.0	1.9	2.2	118.9
Газрын тосны орлого	111.0	33.7	105.0	1.8	1.7
Навигацын орлого	75.9	50.2	32.0	16.0	50.0
Нэр заагдаагүй бусад орлого	53.1	44.1	400.9	62.7	15.6
Хөрөнгийн орлого	0.3	0.4	0.5	2.2	4.8 ¹
Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	0.3	0.4	0.5	2.2	4.8 ¹
Тусламжийн орлого	17.6	11.3	41.3	74.9	181.6
Хандив тусламж, гадаад	17.6	11.3	41.3	74.9	181.6

¹ -дахин их

ЗУРАГ 7. Татварын орлогын бүтэц, хувиар



Татварын нийт орлого 2022 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр **6.9** их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс **1.4** (24.2%) их наяд төгрөгөөр өсөхөд бусад татварын орлого **554.0** (2.2 дахин) тэрбум төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвар **458.9** (34.1%) тэрбум төгрөг, нийгмийн даатгалын орлого **391.9** (39.4%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

Татварын нийт орлогод 2022 оны эхний хагас жилийн байдлаар бусад татварын эзлэх хувь өмнөх оны мөн үеэс **6.5** нэгж хувь, нийгмийн даатгалын орлогынх **2.2** нэгж хувь, нэмэгдсэн өртгийн албан татварынх **1.9** нэгж хувь, гадаад үйл

ажиллагааны орлогынх **0.5** нэгж хувиар тус өсөж, орлогын албан татварынх **10.7** нэгж хувь, онцгой албан татварын орлогын албан татварынх **0.4** нэгж хувиар буурсан байна.

Уул уурхайн салбарын орлого

Коронавируст халдварын цар тахлын тархалтаас сэргийлэх арга хэмжээтэй холбогдуулан БНХАУ-ын талаас газрын тосны экспорт хийгддэг гол боомтыг өнгөрсөн оны 11 сараас энэ оны эхний улирал дуустал хаасан тул гүйцэтгэл бага хэмжээнд байна.

ХҮСНЭГТ 11. Эрдэс бүтээгдэхүүний экспортын төлөвлөгөө, гүйцэтгэл (биет хэмжээгээр)

/тэрбум.төг/	Хэмжих нэгж	2022 Тод	2022 I-VI	Гүйцэтгэлийн хувь
Нүүрсний экспортын хэмжээ	мян.тн	18,000.0	8,081.4	44.9%
Зэсийн баяжмалын экспортын хэмжээ	мян.тн	1,212.9	747.8	61.7%
Төмрийн хүдэр, баяжмалын экспортын хэмжээ	мян.тн	5,056.5	1,749.9	34.6%
Алтны олборлолтын хэмжээ	тн	20.0	7.9	39.6%
Газрын тосны экспортын хэмжээ	мян.бар	3,420.0	114.1	3.3%
Цайрын хүдэр, баяжмалын экспортын хэмжээ	мян.тн	100.0	73.4	73.4%
Хайлуур жоншны хүдэр, баяжмалын экспортын хэмжээ	мян.тн	650.0	167.4	25.7%

Эх үүсвэр: УУХҮЯ

Эрдэс баялгийн салбараас төсөвт төвлөрүүлсэн орлого **1,773.2** тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс **762.0** тэрбум төгрөг буюу **30.1** хувиар буурсан байна. Төсөвт төвлөрүүлсэн орлогын мэдээ, эзлэх хувийг салбараар харуулав.

ХҮСНЭГТ 12. Улсын төсөвт төвлөрүүлсэн орлого

/тэрбум.төг/	2021 I-VI	2022 I-VI	Өөрчлөлт %
Нийт орлого	2,535.1	1,773.2	-30.1%
Уул уурхай, олборлох	2,397.2	1,738.5	-27.5%
Алт	106.2	112.3	5.7%
Зэс	1,672.7	936.7	-44.0%
Нүүрс	431.4	562.0	30.3%
Төмөр	69.9	26.6	-62.0%
Цайр	45.0	53.8	19.6%
Хайлуур жонш	51.7	11.3	-78.1%
Бусад	20.3	35.9	76.3%
Газрын тос	105.0	1.8	-98.3%
Тусгай зөвшөөрлийн төлбөр	33.0	32.9	-0.2%
Тусгай зөвшөөрлийн төлбөр	14.6	15.1	3.7%
УТ-ийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	0.4	0.6	49.4%
Төсөвт байгууллагын өөрийн орлого	16.2	14.5	-10.2%
Бусад орлого	1.8	2.6	48.5%

Эх үүсвэр: УУХҮЯ

Төсвийн зарлага

Улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2022 оны эхний хагас жилд **8.2** их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс **693.7 (9.3%)** тэрбум төгрөгөөр өссөн байна.

Төсвийн зарлагын эрсдэл

БНХАУ-д цар тахлын халдвар эрчимжиж тус улсын Засгийн газраас “Тэг-КОВИД” бодлогыг хэрэгжүүлсний улмаас хилийн боомтын нөхцөл байдал чангарсан, түүнчлэн ОХУ, Украины нөхцөл байдлаас шалтгаалан дэлхийн зах зээлд түүхий эдийн үнэ өссөний улмаас хэрэглээний үнийн өсөлт нэмэгдэж 2022 оны 6 дугаар сарын байдлаар Монгол Улсын инфляцын түвшин 16.1 хувьд хүрээд байна.

ЗГ-с авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

Монгол Улсын 2022 оны төсвийн тодотголын төслийг боловсруулахдаа бодлогын дараах 3 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

- Төрийн хэмнэлтийн бодлого
 - Төрийн тусгай албан хаагчаас бусад төрийн албан хаагч дүрэмт хувцас хэрэглэхийг хориглоно.
 - Төрийн жинхэнэ болон төрийн үйлчилгээний албан хаагч, төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн албан хаагчийн албан тушаалын автомашины ашиглалтыг хязгаарлана.
 - Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй автомашины ашиглалтад хяналт тавина.
 - Төрийн жинхэнэ болон төрийн үйлчилгээний албан хаагч, төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн албан хаагч албан томилолтоор нислэг үйлдэх бол зөвхөн энгийн зэрэглэлээр үндэсний агаарын тээврийг сонгож үйлчлүүлнэ.
 - Бүх шатны төсвийн байгууллагын албан хаагчийн ажиллах орчин, техник хэрэгслийн нийтлэг жишгийг шинэчлэн батлуулна.
 - Захиргааны зориулалттай барилга, байгууламж шинээр барихгүй.
 - Төрийн албан хаагчийн гар утас, шатахууны төлбөр зэрэг бусад хангамжийн зардлыг төсвөөс санхүүжүүлэхгүй.
 - Төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг агентлаг, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллага дэд, орлогч даргатай байна.
 - Төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
 - Төсөвт байгууллагыг хэмнэлтийн горимд үргэлжлүүлэн ажиллуулна.
- Цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого
- Иргэдийн орлого, ажлын байрыг хамгаалах, амьжиргааг дэмжих, нийгмийн баталгааг сайжруулах бодлого
 - Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох эрх зүйн зохицуулалтыг бий болгоно.
 - Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 2022 оныг дуустал 100 мянган төгрөгөөр бэлнээр үргэлжлүүлэн олгоно.
 - Импортын хүнсний ногоог орлох дотоодын үйлдвэрлэлийг дэмжинэ.
 - Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулна.
 - Нийтлэг үйлчилгээний төрийн албан хаагчийн цалинг 1 шатлалтай болгоно.


ХҮСНЭГТ 13. Улсын нэгдсэн төсвийн зарлага, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар

Зарлагын төрөл /тэрбум.төг/	2019 I-VI	2020 I-VI	2021 I-VI	2022 I-VI	Өөрчлөлт 2021/2022
НИЙТ ЗАРЛАГА, ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ХЭМЖЭЭ	4 708.3	6 298.3	7 498.2	8 191.9	109.3
НИЙТ ЗАРЛАГА	4 598.4	6 279.6	7 419.3	8 163.7	110.0
УРСГАЛ ЗАРДАЛ	3 962.3	5 050.8	6 559.6	7 004.8	106.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1 885.3	2 164.2	2 056.3	1 640.0	79.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1 158.0	1 339.2	1 295.4	827.2	63.9
Үндсэн цалин	858.7	950.3	917.3	545.9	59.5
Нэмэгдэл	216.3	291.1	291.2	212.9	73.1
Унаа хоолны хөнгөлөлт	26.8	29.3	26.7	31.1	116.4
Урамшуулал	42.3	54.3	45.8	19.6	42.8
Гэрээт ажлын хөлс	13.9	14.1	14.3	17.7	123.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	133.4	141.5	138.8	162.9	117.4
Гэрэл, цахилгааны зардал	25.2	26.6	23.4	29.7	126.9
Түлш, халаалтын зардал	86.2	92.5	94.1	105.2	111.8
Цэвэр, бохир усны зардал	11.4	9.8	7.4	12.0	162.6
Байрны түрээс	10.6	12.6	13.9	16.0	115.3
Хангамж, бараа материалын зардал	62.8	76.9	73.0	80.7	110.6
Нормативт зардал	134.9	142.5	79.5	111.2	140.0
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	68.0	71.1	41.1	34.7	84.4
Хоолны зардал	50.5	49.6	22.6	58.6	2.6 ¹
Нормын хувцас, зөөлөн эдлэл авах зардал	16.4	21.8	15.8	18.0	114.4
Эд хогшил, урсгал засварын зардал	33.1	35.6	25.4	39.5	155.8
Томилолт, зочны зардал	13.6	7.1	4.6	9.9	2.2 ¹
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	208.3	238.1	264.5	247.1	93.4
Бараа үйлчилгээний бусад зардал	141.2	183.3	175.2	161.4	92.1
Бараа үйлчилгээний бусад зардал	124.2	168.5	162.0	152.3	94.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17.0	14.8	13.2	9.1	69.2
ХҮҮ	436.8	425.2	420.1	415.6	98.9
Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	341.0	379.7	355.0	360.1	101.4
Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	95.8	45.5	65.1	55.5	85.2
ТАТААС	123.0	376.8	202.7	267.9	132.2
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	32.8	49.0	26.0	69.9	2.7 ¹
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	90.2	327.9	176.7	198.0	112.1
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1 517.2	2 084.5	3 880.5	4 681.3	120.6
Засгийн газрын урсгал шилжүүлэг	39.7	85.7	385.5	2 575.0	6.7 ¹
Бусад урсгал шилжүүлгүүд	1 477.5	1 998.8	3 495.0	2 106.3	60.3
НД-н тэтгэвэр тэтгэмж	997.5	1 174.6	1 249.2	1 590.5	127.3
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	341.1	641.1	1 003.6	279.0	27.8
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2.0	2.5	1.6	2.8	2.3 ¹
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	58.9	96.5	174.7	120.7	69.1
Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	0.0	0.0	0.0	0.0	-
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	52.1	55.8	35.5	53.7	151.2

Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	21.3	21.9	14.1	54.5	3.9 ¹
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4.6	6.3	1 016.2	5.0	0.5
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	636.1	1 228.9	859.6	1 158.9	134.8
Барилга байгууламж	469.9	763.1	490.1	911.4	186.0
Их засварын зардал	30.7	31.4	23.5	35.2	149.9
Тоног төхөөрөмж	24.2	153.6	86.7	50.6	58.4
Бусад хөрөнгө	100.8	266.7	250.4	159.8	63.8
Стратегийн нөөц хөрөнгө	10.4	14.0	9.0	1.9	21.1
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	109.9	18.7	78.9	28.2	35.7
Эргэж төлөгдөх цэвэр зээл	58.2	- 24.8	15.1	- 34.8	-
Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	51.6	43.5	63.8	62.9	2.4 ¹

¹ -дахин их

ЗУРАГ 8. Урсгал зардлын бүтэц, хувиар



Зарлагын өсөлтөд урсгал шилжүүлгийн зардал өмнөх оны мөн үеэс **800.9** (20.6%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна. Харин бараа үйлчилгээний зардал **416.4** (20.2%) тэрбум төгрөг, хүүгийн зардал **4.6** (1.1%) тэрбум төгрөгөөр буурчээ.

Урсгал зардалд урсгал шилжүүлгийн эзлэх хувь 2022 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс **7.7** нэгж хувь,

татаас **0.8** нэгж хувиар өсөж, харин бараа үйлчилгээний зардлынх **7.9** нэгж хувь, хүүгийн зардал **0.5** нэгж хувиар буурсан байна.

Хөрөнгийн зардал **1.2** их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс **299.3** (34.8%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Хөрөнгийн зардалд барилга байгууламжийн зардлын эзлэх хувь өмнөх оны мөн үеэс **21.6** нэгж хувь, их засварын зардлынх **0.3** нэгж хувиар өсөж, бусад хөрөнгийн зардлынх **15.3** нэгж хувь, тоног төхөөрөмжийн зардлынх **5.7** нэгж хувь, стратегийн нөөц хөрөнгийн зардлынх **0.9** нэгж хувиар тус тус буурчээ.

Нийгмийн даатгалын сангийн төсөв

Нийгмийн даатгалын сангийн орлого 2022 оны эхний хагас жилд **1.6** их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс **415.3** (34.2%) тэрбум төгрөг, нийт зарлага **1.6** их наяд төгрөг болж, **339.7** (26.9%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

ХҮСНЭГТ 14. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар

Үзүүлэлт /тэрбум.төг/	2019 I-VI	2020 I-VI	2021 I-VI	2022* I-VI	2022* I-VI 2021 I-VI
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	1,174.2	1,042.3	1,215.5	1,630.8	134.2
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ОРЛОГО	871.5	758.8	944.5	1,225.6	129.8
Тэтгэврийн даатгалын шимтгэл	657.0	573.6	823.2	1,026.4	124.7
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	81.9	72.1	57.5	99.0	172.1
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	110.0	94.7	50.6	81.5	161.1
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	22.6	18.3	13.2	18.7	142.0
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	302.7	283.6	271.0	405.2	149.5
НИЙТ ЗАРЛАГА	1,009.6	1,187.3	1,260.6	1,600.3	126.9
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРЛАГА	11.6	12.3	12.1	12.7	105.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8.4	9	9.1	9.8	108.0
Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	1	1.1	1.2	1.2	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.5	0.6	0.6	0.6	101.7
Хангамж, бараа материалын зардал	0.3	0.4	0.3	0.3	114.7
Эд хогшил, урсгал засварын зардал	0.1	0.1	0	0.2	28.8 ¹
	0.1	0		0	
Томилолт, зочны зардал			-		-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	1	1	0.9	0.6	63.2
Бараа үйлчилгээний бусад зардал	0.1	0	0	0.1	176.6
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	998.0	1,175.0	1,249.6	1,591.0	127.3
Бусад урсгал шилжүүлэг	998.0	1,175.0	1,249.6	1,591.0	127.3
Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	997.5	1,174.6	1,249.1	1,590.4	127.3
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж	0.2	0.0	0.1	0.2	142.9
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгө	0.4	0.3	0.4	0.5	142.4
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.0	0.1	-	-	-
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	-	(1.1)	(3.5)	3.2 ¹
ТЭНЦЭЛ (+, -)	164.7	(145.0)	(45.1)	30.6	-

¹ -дахин их

Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 2022 оны эхний хагас жилд **723.2** тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс **240.6** (49.9 хувь) тэрбум төгрөг, нийт зарлага 1.1 их наяд төгрөг болж, **540.9** (2.0 дахин) тэрбум төгрөгөөр тус өссөн байна. Нийт зардал өсөхөд засгийн газрын урсгал шилжүүлгийн зардал өмнөх оны мөн үеэс **520.6** (2.1 дахин) тэрбум төгрөгөөр өссөн нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 15. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлага, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар

Үзүүлэлт /тэрбум.төг/	2019 I-VI	2020 I-VI	2021 I-VI	2022* I-VI	2022* I-VI 2021 I-VI
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	214.9	213.1	482.5	723.2	149.9
ЭМД-ын хураамжийн шимтгэл	214.9	213.1	482.5	723.2	149.9
НИЙТ ЗАРЛАГА	163.7	198.3	518.0	1,058.9	2.0¹
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРЛАГА	1.5	1.7	6.3	9.4	148.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.7	0.9	1.5	2.0	130.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.1	0.1	0.3	0.2	68.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.0	0.0	0.1	0.1	152.9
Хангамж, бараа материалын зардал	0.1	0.1	0.1	0.1	140.9
Эд хогшил, урсгал засварын зардал	0.1	0.1	0.1	0.0	38.3
Томилолт, зочны зардал	0.1	0.1	0.0	0.0	3.5 ¹
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.3	0.4	1.3	6.8	5.2 ¹
Бараа үйлчилгээний бусад зардал	0.1	0.1	2.9	0.1	2.2
ТАТААС	17.2	21.1	32.7	52.5	160.5
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	145.0	175.5	479.5	1,000.2	2.1¹
Засгийн газрын урсгал шилжүүлэг	144.9	175.4	479.5	1,000.1	2.1 ¹
Бусад урсгал шилжүүлэг	0.1	0.1	0.0	0.2	3.4 ¹
Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	0.1	0.0	0.0	0.1	5.9 ¹
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.0	-	0.0	-	-
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	0.0	0.0	0.0	195.3
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	-	(0.6)	(3.2)	5.5¹
ТЭНЦЭЛ	51.2	14.8	(35.4)	(335.7)	9.5¹

¹ -дахин их

Улсын төсвийн хөрөнгө оруулалт

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар улсын хэмжээнд нийт **6,152.3** тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй **1,393.7** тэрбум төгрөгийн санхүүжилт бүхий **1369** төсөл, арга хэмжээ хэрэгжихээр батлагдсан, мөн өмнөх онуудад концессын “Барих-Шилжүүлэх” төрлөөр гэрээ байгуулсан төслүүдийн гэрээний эргэн төлөлтөд 7 төслийн **303.6** тэрбум төгрөг, нийт **1,697.3** тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдсан.

ХҮСНЭГТ 16. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хагас жилийн гүйцэтгэл

Төсвийн ерөнхийлөн захирагч /сая.төг/	Төслийн тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Гүйцэтгэл 2022.06	Гүйцэтгэл. хувь	2022 ХБГ* 90%
Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга	2	1,500.0	712.7	177.8	24.9%	641.4
Монгол Улсын Их Хурлын дарга	1	2,114.5	2,114.5	-	0.0%	1,903.1
Монгол Улсын Ерөнхий сайд	45	176,252.6	46,983.6	5,761.5	12.3%	42,285.2
Монгол Улсын Шадар сайд	8	38,486.9	9,147.9	4,068.3	44.5%	8,233.1
Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга	31	76,256.2	21,770.2	3,129.1	14.4%	19,593.2
Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	31	49,780.8	17,774.6	1,397.9	7.9%	15,997.1
Батлан хамгаалахын сайд	7	23,614.9	12,457.4	7,281.1	58.4%	11,211.6
Гадаад харилцааны сайд	3	8,400.0	8,400.0	8,376.8	99.7%	7,560.0
Сангийн сайд	7	237,538.9	77,353.2	23,557.9	30.5%	69,617.9
Хууль зүй, дотоод хэргийн сайд	44	120,772.7	62,746.1	28,064.1	44.7%	56,471.5
Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд	40	120,212.7	28,827.9	7,839.8	27.2%	25,945.1
Барилга, хот байгуулалтын сайд	227	1,084,235.3	223,270.4	21,738.7	9.7%	200,943.4
Боловсрол, шинжлэх ухааны сайд	430	1,465,095.9	356,973.8	62,212.6	17.4%	321,276.4
Соёлын сайд	87	481,220.0	74,425.8	8,289.6	11.1%	66,983.2
Зам, тээврийн хөгжлийн сайд	129	1,296,189.2	230,790.6	52,466.1	22.7%	207,711.5
Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	1	4,731.0	1,354.7	153.5	11.3%	1,219.2
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	77	150,600.2	41,307.8	5,807.2	14.1%	37,177.0
Эрчим хүчний сайд	55	348,256.9	80,913.6	10,560.7	13.1%	72,822.2
Эрүүл мэндийн сайд	118	387,573.7	72,898.9	16,530.8	22.7%	65,609.0
Авлигатай тэмцэх газрын дарга	1	1,043.0	1,043.0	66.4	6.4%	938.7
Шүүхийн ерөнхий зөвлөл	2	4,000.0	4,000.0	-	0.0%	3,600.0
Улсын ерөнхий прокурор	5	14,453.5	6,219.5	1,609.7	25.9%	5,597.6
Үндэсний статистикийн газрын дарга	1	2,158.2	2,158.2	1,222.7	56.7%	1,942.4
Монгол Улсын ерөнхий аудитор	1	1,526.1	1,526.1	219.3	14.4%	1,373.5
Улсын дээд шүүгчийн ерөнхий шүүгч	1	743.8	743.8	-	0.0%	669.4
Шүүхийн сахилгын хорооны дарга	1	1,000.0	1,000.0	471.1	47.1%	900.0
Хүний эрхийн үндэсний комиссын дарга	1	142.0	142.0	-	0.0%	127.8
Санхүүгийн зохицуулах хорооны дарга	1	572.5	114.5	-	0.0%	103.1
Цахим хөгжил харилцаа холбооны сайд	11	38,218.8	6,384.8	-	0.0%	5,746.3
Эдийн засаг хөгжлийн сайд	1	15,634.1	200.0	-	0.0%	180.0
УЛСЫН ТӨСВИЙН ДҮН	1369	6,152,324.4	1,393,755.5	271,002.9	19.4%	1,254,379.9
КОНЦЕССЫН ДҮН	7	937,124.9	303,600.0	225,299.7	74.2%	303,600.0
НИЙТ	1376	7,089,449.3	1,697,355.5	496,302.6	29.2%	1,557,979.9

*- Хүлээгдэж буй гүйцэтгэл

Гадаад зээл, тусламжийн ашиглалт

Засгийн газрын гадаад зээл, тусламжаар 2022 онд хэрэгжих төсөл арга хэмжээг нийгэм, эдийн засгийн ач холбогдол өндөртэй томоохон бүтээн байгуулалтад чиглүүлэх, хэрэгжиж байгаа төслүүдийг хугацаанд нь дуусгах бодлого чиглэлийг баримталж, гадаад зээл, тусламжийн төслүүдийн санхүүжилт, гаалийн татвар чөлөөлөлтийг бүтэн цахимжуулах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна.

ХҮСНЭГТ 17. Гадаад зээл, тусламжийн хүлээгдэж буй гүйцэтгэл

ЗАРДЛЫН АНГИЛАЛ	2022 I-VI	ГҮЙЦЭТГЭЛ ХУВЬ	2022 ХБГ*
Гадаад зээл, тусламж	670.1	42%	1,606.1
урсгал зардал	87.9	42%	211.1
хөрөнгийн зардал	499.1	45%	1,115.0
эргэн төлөгдөх	83.1	30%	280.0
Гадаад төслийн зээл	600.4	46%	1,307.6
урсгал зардал	77.7	47%	164.6
хөрөнгийн зардал	439.6	51%	863.0
эргэн төлөгдөх	83.1	30%	280.0
Гадаад тусламж	69.7	23%	298.5
урсгал зардал	10.2	22%	46.5
хөрөнгийн зардал	59.5	24%	252.0

*- Хүлээгдэж буй гүйцэтгэл

Монгол Улсын 2022 оны төсвийн тодотголоор гадаад төслийн зээлийн ашиглалт 1,307.6 тэрбум төгрөг, тусламжийн ашиглалт 298.5 тэрбум төгрөгөөр батлагдсан. Эхний хагас жилийн байдлаар гадаадын зээл, тусламжийн ашиглалт 42 хувьд хүрсэн бол эхний хагас жилд төлөвлөгдсөн дүнтэй харьцуулбал 76 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд, зээлийн төслийн ашиглалт 46 хувь, гадаад тусламжийн төслийн ашиглалт 23 хувьтай байна.

Жилийн сүүлийн хагаст бүтээн байгуулалтын томоохон төслүүдийн гүйцэтгэлийг санхүүжүүлэх бөгөөд хүлээгдэж буй гүйцэтгэлээр зээл, тусламжийн ашиглалт 1.6 их наяд буюу ДНБ-ний 3.4 хувьтай, нэгдсэн төсвийн нийт зарлагын 8.9 хувьтай байхаар тооцогдож байна.

ХҮСНЭГТ 18.Гадаад зээл, тусламж хөгжлийн түншээр

ХӨГЖЛИЙН ТҮНШ	2022 I-VI		ГҮЙЦЭТГЭЛ ХУВЬ		2022 ХБГ*	
	зээл	тусламж	зээл	тусламж	зээл	тусламж
Австри	9.4	-	53%		17.8	-
АДБХОБ	-	-	0%		1.0	-
АХБ	159.8	16.5	32%	23%	500.9	70.5
Беларусь	-	-	0%		0.0	-
БНСУ	82.6	-	59%		140.8	-
БНФУ	35.9	-	95%		37.8	-
БНХАУ	109.8	18.1	73%	20%	149.8	89.5
БНЭУ	71.8	-	59%		122.4	-
Дэлхийн банк	66.5	0.9	36%	5%	182.5	17.7
ЕСБХБ	32.0	-	41%	0%	77.4	8.6
ЕХОБ	5.2	-	21%		25.0	-
Польш	12.5	-	44%		28.7	-
Унгар	-	-	0%		0.0	-
ХААХОУС	1.3	-	24%		5.4	-
ХБНГУ	0.3	3.2	13%	25%	2.6	12.7
Япон	13.1	-	84%		15.6	-
АНУ	-	28.4		31%	-	91.5
Кувейт	-	2.1		30%	-	6.8
Люксембург	-	0.6		50%	-	1.2
НИЙТ	600.4	69.7	46%	23%	1,307.6	298.5

*- Хүлээгдэж буй гүйцэтгэл

2022 онд авч ашиглах нийт зээл, тусламжийн 55.3 хувийг хөгжлийн түнш олон улсын байгууллага, 44.7 хувийг хөгжлийн түнш улс орнуудын эх үүсвэр бүрдүүлж байна.

Тухайлбал, АХБ-ны зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл”-ийн хүрээнд Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын өргөтгөл, шинэчлэл хийгдэж, хэсэгчлэн ашиглалтад орохоор төлөвлөгдсөн. Мөн “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төсөл”-ийг 3 үе шаттай хэрэгжүүлж байгаагаас эхний үе шат дуусна. Тус төслөөр улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, шинэ дэд бүтцийг бий болгох, эрчим хүч, дулаан хангамжийг сайжруулах ажил хийгдэж байна.

БНХАУ-ын тусламжаар хэрэгжиж буй “Хилийн боомтын дэд бүтэц төсөл”-ийн хүрээнд Замын-Үүд боомтын зорчигч тээврийн хэсэг шинээр ашиглалтад орох, мөн БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжсэн Замын цагдаагийн гүүрэн гарцын явган зорчигчийн хэсэг, 2 туслах эргэлтийн зам ашиглалтад орж байна. Түүнчлэн Австри улсын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэг, Дархан-Уул, Сэлэнгэ аймагт гэр хорооллын гудамж, зам, талбайн нийт 12,613 ш гэрэлтүүлэг тохижилтын ажил хийгдэж дуусахаар ажил үргэлжлэн хэрэгжиж байна.

Засгийн газрын өр

Өрийн удирдлагын тухай хуулийн дагуу Сангийн яам нь “Засгийн газрын өр”-ийн үлдэгдлийг улирал тутам тооцон бэлтгэж, олон нийтэд мэдээлж байна

Засгийн газрын өрийн үлдэгдлийг өрийн хэрэгсэл тус бүрээр авч үзвэл 2020-2021 оны хооронд Засгийн газрын өрийн баталгаа 17.3 хувиар, Засгийн газрын гадаад өрийн үлдэгдэл 1.6 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

ХҮСНЭГТ 19. Засгийн газрын өрийн бүтэц, тэрбум төгрөг

ӨРИЙН ХЭРЭГСЭЛ /тэрбум.төг/	2020 Гүйц	2021 I-VI	2021 УГ*	2022 I-VI	2022 ХБГ**
I. Засгийн газрын дотоод өр	1,136.60	1,046.10	657.3	531.8	2,165.7
Үнэт цаас	1,136.60	1,046.10	657.3	531.8	2,165.7
II. Засгийн газрын гадаад өр	24,851.40	24,371.00	24,693.30	26,538.10	28,722.2
Үнэт цаас	8,354.00	7,976.20	8,175.60	8,994.90	8,745.8
Зээл	16,497.40	16,394.80	16,517.70	17,543.20	19,976.4
III. Засгийн газрын бусад өр	1,910.60	1,717.80	1,550.40	1,432.50	4,685.4
Засгийн газрын өрийн баталгаа	1,060.40	955.30	876.5	940.7	4,015.3
"Барих-шилжүүлэх" төрлийн концесс	850.2	762.5	673.9	470.8	649.1
Орон нутгийн зээллэг	-	-	17.2	21	21.0
ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР (I+II+III)	27,898.60	27,135.00	26,918.10	28,502.40	35,573.3
ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)	23,024.30	22,337.80	21,837.30	23,825.00	29,399.4
Хуулиар тогтоосон өрийн хязгаар	70.0%	70.00%	70.0%	70.00%	70.0%
Засгийн газрын өр (ӨҮЦ) / ДНБ	62.3%	51.93%	50.7%	50.8%	61.8%


*- Урьдчилсан гүйцэтгэл

** - Хүлээгдэж буй гүйцэтгэл

Засгийн газрын өрийн үлдэгдэл 2021 оны жилийн эцсийн байдлаар нэрлэсэн дүнгээр 26.9 их наяд төгрөг, өнөөгийн үнэ цэнээр ДНБ-ий 62.3 хувьд хүрээд байсан бол 2022 оны жилийн эцсийн байдлаар 28.2 их наяд төгрөг, өнөөгийн үнэ цэнээр ДНБ-ий 61.8 хувьд хүрэх төлөвтэй байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан өрийн тухай төсвийн тусгай шаардлагад өнөөгийн үнэ цэнэ /ӨҮЦ/-ээр илэрхийлэгдсэн Засгийн газрын өрийн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувь 2021-2022 онуудад 70 хувиас, 2023 онд 65 хувь, 2024 оноос эхлэн 60 хувиас тус тус хэтрэхгүй байхаар хуульчлагдсан.

ЗУРАГ 9. Монгол Улсын Засгийн газрын өр, тэрбум.төг



Засгийн газрын өрийн үлдэгдэл (ӨҮЦ)-ийн ДНБ-д эзлэх харьцаа 2021 онд 50.8 хувийн гүйцэтгэлтэй байгаагаас 2022 онд 61.8 хувьд хүрэхээр байгаа нь хуулийн хязгаарыг хангахаар байна. Засгийн газрын өрийн тухай төсвийн тусгай шаардлагын тооцоолол нь ирэх онуудад бий болох эдийн засгийн өсөлт, Засгийн газрын өрийн баталгаа гаргах хэмжээ, валютын ханшийн тооцоолол болон төсвийн алдагдал зэрэг макро эдийн засгийн суурь хүчин зүйлсээс шалтгаална.

Засгийн газрын дотоод үнэт цаас


ЗУРАГ 10. Монгол Улсын Засгийн газрын өр, тэрбум.төг



Засгийн газар 2017 оны 10 дугаар сараас хойш дотоод зах зээлд Засгийн газрын үнэт цаас арилжаалаагүй тул дээрх хугацаанаас хойш дотоод үнэт цаасны үлдэгдэл 5 дахин буурч 2021 оны жилийн эцсийн байдлаар **657.3** тэрбум төгрөгт хүрсэн.

Засгийн газрын гадаад үнэт цаас

ЗУРАГ 11. Гадаад үнэт цаасны хүү




Засгийн газрын зүгээс стратегийн баримт бичгийн хэрэгжилтийг хангах, дунд хугацааны төлбөрийн дарамтыг бууруулах зорилгоор 2021 онд “Сенчири” төслийн хүрээнд хугацаа тулаад байсан 2012 онд гаргасан “Чингис” бонд болон 2017 онд гаргасан “Гэрэгэ” бондын өр төлбөрийн тодорхой хувийг дахин санхүүжилт хийж өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн бөгөөд түүхэндээ хамгийн бага түвшний хүүтэйгээр буюу 6 жилийн хугацаатай **3.5** хувийн хүүтэй **500** сая ам.доллар, 10 жилийн хугацаатай **4.45** хувийн

хүүтэй, **500** сая ам.доллар, нийт **1.0** тэрбум ам.долларын өр төлбөрийг шийдвэрлэсэн.

Засгийн газрын гадаад зээл

ЗУРАГ 12. Гадаад зээл



Монгол Улсын Засгийн газрын зүгээс 1991 оноос 2021 оны хооронд нийт 7,685.2 сая ам.доллартой тэнцэх хэмжээний ашиглалтыг 22 зээлдүүлэгчийн 326 төсөл хөтөлбөрт зарцуулсан. Үүнээс 2022 оны хагас жилийн байдлаар 1,886.7 сая ам.долларыг эргэн төлж 5,798.5 сая ам.доллартой тэнцэх үлдэгдэлтэй байна.


Энэхүү гадаад зээлийн ашиглалтыг төслийн зээлийн хүрээнд 5,002.0 сая ам.доллар, хөтөлбөрийн зээлийн хүрээнд 2,685.2 сая ам.доллартой тэнцэх хэмжээний хөрөнгийг ашигласан бөгөөд гадаад төслийн зээлийн ашиглалтын 39.5 хувийг барилгын ажил, 26.2 хувийг тоног төхөөрөмж, 14.4 хувийг үйл ажиллагааны зардал, 12.7 хувийг зөвлөх үйлчилгээний зардалд, 5.1 хувийг

магадлашгүй зардалд, үлдсэн 2.1 хувийг санхүүгийн шимтгэлд зарцуулсан байна.

Засгийн газрын гадаад төслийн зээлийн ашиглалтын хамгийн их хэсэг буюу 2,332.6 сая ам.доллартой тэнцэх хэмжээний хэсгийг дэд бүтцийн буюу зам, тээвэр, эрчим хүч, орон сууц, нийтийн аж ахуйн салбаруудад, 1,461.8 сая ам.доллартой тэнцэх хэмжээний хэсгийг эргэлтийн хөрөнгө буюу жижиг дунд үйлдвэрлэлийн зээл, барааны зээл, банк санхүүгийн салбарт зэрэгт зарцуулсан бол үлдсэн 1,207.6 сая ам.доллартой тэнцэх хэмжээний хэсгийг нийгмийн шинж чанартай төсөл, арга хэмжээнүүд болох эрүүл мэнд, боловсрол, онцгой байдал зэрэг салбарын төслүүдэд авч ашигласан.

Барих-шилжүүлэх концесс

ЗУРАГ 13. Барих-шилжүүлэх төрлийн концессын үлдэгдэл



Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй 10 концессын гэрээний үлдэгдэл 2021 оны жилийн эцэст 673.5 тэрбум төгрөгтэй тэнцэж байгаа бол орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй 3 концессын гэрээний хүрээнд 0.4 тэрбум төгрөгийг 2021 онд төлж барагдуулсан байна. Засгийн газар 2017 оноос хойш шинээр “Барих-шилжүүлэх” төрлийн концессын гэрээ байгуулаагүй бөгөөд өмнөх жилүүдэд байгуулагдсан гэрээний ашиглалтын хүрээнд өрийн үлдэгдэл нэмэгдэж ирсэн.

III. Макро эдийн засаг, төсвийн төсөөлөл

Эдийн засгийн өсөлт

Засгийн газар өнгөрсөн 2 жилд цар тахлын нөхцөл байдлаас үүдсэн эдийн засгийн уналтыг сааруулж, эдийн засгийг сэргээх мөчлөг сөрсөн бодлого хэрэгжүүлж ирсэн бол дунд хугацаанд эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлж урт хугацааны зорилтыг хангах сэргэлтийн бодлогуудыг авч хэрэгжүүлэхээр “Шинэ сэргэлт”-ийн бодлогыг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Коронавируст халдварт цар тахал, дэлхий дахины геополитикийн тогтворгүй байдал, үүнээс үүдэлтэй олон улсын зах зээлийн тодорхой бус байдал нь манай улсын эдийн засагт сөргөөр нөлөөлөх төлөвтэй байгаа тул Засгийн газраас төсвийн хэмнэлтийн бодлого баримталж байна. Түүнчлэн, Монголбанкнаас төв банкны бодлогын хүүг он гарснаас хойш 3 удаа шат дараалан нэмэгдүүлж 10% хувьд хүргэсэн нь зээлийн өсөлтийг бууруулах замаар салбаруудын өсөлтөд сөргөөр нөлөөлж байна.

Дотоод эдийн засгийн идэвхжил сул, макро эдийн засгийн тогтворгүй байдал үүсээд байгаа хэдий ч Засгийн газраас гадаадын хөрөнгө оруулалт татах, хилийн боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх, гол нэр төрлийн бараа бүтээгдэхүүнүүдийн үнийг тогтворжуулах зэрэг эдийн засгийн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлж, дунд хугацаанд цар тахлын өмнөх эдийн засгийн түвшиндээ хүрэх зорилтыг тавьж байна.

“Шинэ сэргэлт”-ийн бодлогыг хэрэгжүүлснээр дунд хугацаанд хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлсийг арилгаж, томоохон төсөл хөтөлбөрүүдийг /Газрын тос боловсруулах үйлдвэр, Богдхан төмөр зам, Оюутолгойн далд уурхай зэрэг/ эрчимжүүлж барилга, бүтээн байгуулалтыг эхлүүлснээр эдийн засгийн өсөлтийг дэмжиж байна.

Засгийн газраас хэрэгжүүлж буй эдийн засгийг сэргээх дунд хугацааны бодлого, гадаад орчны нөхцөл байдлаас үүсэж буй эрсдэл, эдийн засагт үүсээд байгаа богино хугацааны хүндрэлийг даван туулах бодлогуудын нөлөөг уялдуулан тооцсон бодит ДНБ 2022 онд 2.6 хувиар өсөхөөр хүлээгдэж байна.

Гадаад худалдаа

Монгол Улсын гадаад худалдааны нийт эргэлт 2022 онд 19.2 тэрбум ам.долларт, гадаад худалдааны тэнцэл 2.5 орчим тэрбум ам.долларын ашигтай байхаар байна.

Экспортын хилийн боомтууд дээр хийгдэж буй өргөтгөл, шинэчлэлийн ажлуудын нөлөөгөөр нүүрсний экспортын хэмжээ төлөвлөж байснаас өсөхөөр хүлээгдэж байна. Мөн дэлхийн зах зээл дэх түүхий эд, эрдэс бүтээгдэхүүнүүдийн өндөр үнэ хэвээр хадгалагдахаар байгаа тул экспортын хэмжээ 10.8 орчим тэрбум ам.долларт хүрэхээр хүлээгдэж байна.

Дэлхий нийтээр үүсээд байгаа Коронавируст халдварт цар тахал болон улс орнуудын зөрчилдөөнтэй байдлаас шалтгаалан өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, нефтийн бүтээгдэхүүний үнэ өсөлттэй байна. Мөн тээврийн зардал өссөнтэй холбоотойгоор импортын хэмжээ 2022 онд 8.3 орчим тэрбум ам.долларт хүрэхээр байна.

Инфляц

Коронавируст халдварт цар тахлын эсрэг вакцинжуулалт амжилттай хэрэгжсэнээр цар тахал хумигдаж, дотоодын эдийн засаг сэргэж байгаа ч гадаад зах зээлээс хамаарсан тодорхой бус байдал манай улсын импортын шатахуун болон хүнсний барааны үнийг нэмэгдүүлж, инфляцын дарамтыг бий болгож байна.

Монгол Улсын Засгийн газраас эдийн засгийг сэргээх чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого арга хэмжээг 2022 онд үргэлжлүүлэхийн зэрэгцээ “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд боомтын сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлснээр хилийн саатлаас шалтгаалсан импортын бараа, түүхий эдийн үнийн өсөлт дунд хугацаанд тогтворжихоор байна.

Иймд, инфляцын түвшин 2022 онд Монголбанкны зорилт болох 6 ± 2 нэгж хувийн интервалын дээд хязгаарыг давахаар байна.

Төсвийн орлого

Монгол Улсын Засгийн газраас эдийн засгаа тэлж, төсвийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг үргэлжлүүлэн, боомтын шинэчлэлийн ажлыг эрчимжүүлж, гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого хэрэгжүүлж байна

Түүнчлэн, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын нөлөөний дараа дэлхийн эдийн засаг сэргэж, олон улсын зах зээл дээрх зэсийн үнийг тонн тутамд 9,300 орчим ам.долларт хэлбэлзэхээр тооцоолж байна.

Төсвийн зарлага

Дэлхий нийтийг хамарсан Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас шалтгаалан үүссэн эдийн засгийн хүндрэлийн үед бүх шатандаа хэмнэлтийн бодлого баримталж төсвийн бүх шатны байгууллагууд “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, “Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 388 дугаар тогтоолыг тус тус мөрдөн ажиллаж байна.

Төсвийн хэмнэлтийн хүрээнд төрийн байгууллагуудын гадаад, дотоод албан томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах, тавилга, эд хогшил, ном хэвлэл худалдан авах, сурталчилгаа хийх, бэлэг дурсгалын зүйлс бэлтгэх, уралдаан тэмцээн, тэмдэглэлт ой, баяр ёслолын арга хэмжээ зохион байгуулах, автомашин худалдан авах, захиргааны байгууллагуудад засвар тохижилт хийх болон бичиг хэргийн зардлын санхүүжилтийг түр хойшлуулах болон бууруулах арга хэмжээ авч байна.

Хэдийгээр Засгийн газраас эдийн засаг, нийгмийн цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан төсвийн зарлагын өсөлтийг хязгаарлах, төсвийн тэнцлийг сайжруулах зорилгоор төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай шийдвэр удаа дараа гаргаж ирсэн боловч зөвхөн тухайн санхүүгийн жилд хэрэгжиж цаашид тогтвортой мөрдөгдөхгүй байхын зэрэгцээ төсвийн байгууллагуудад тэгш бус үйлчилж ирсэн байна.

Хэмнэлтийг зөвхөн төсвийн байгууллагуудад цаг үеийн шинжтэй байдлаар хэрэгжүүлэх бус харин үндэсний хэмжээнд нэгдсэн байдлаар, улсын салбарын бүх хуулийн этгээд, албан тушаалтныг хамруулж, байнгын шинжтэй хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага үүсээд байна.

Иймд төрийн бүх шатанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлэн ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлын эсрэг хязгаарлалт тогтоох, хяналт тавих зорилгоор Засгийн газраас 2022 оны төсвийн тодотголтой хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн төслийг Улсын Их Хурал хэлэлцэн батлаад байна.

Хэмнэлтийн горимыг байнгын шинжтэй мөрдөж хэрэгжүүлснээр төрийн бүх шатанд үрэлгэн байдал арилж, төсвийн зарцуулалтын үр ашиг сайжрах, төсвийн зарлагын өсөлт дунд болон урт хугацаанд буурах ач холбогдолтой байх болно.

Засгийн газрын өрийн төсөөлөл

Засгийн газрын зүгээс “Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичиг”-ийг боловсруулж үндсэн 6 зорилтыг дэвшүүлэн батлуулахаар ажиллаж байна

- Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн нийгмийн үр өгөөж, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх.
- Өрийн зохицуулалтын арга хэмжээ.
- Засгийн газрын өрийн удирдлагын тогтолцоог сайжруулж орчин үеийн чиг хандлагад нийцүүлэх, Засгийн газрын өрийн багц дахь зах зээлийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор үүсмэл арга хэрэгслийг нэвтрүүлэх.
- Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжих зорилгоор арилжааг тогтмолжуулах.
- Улсын стратегийн томоохон төслүүдэд Засгийн газрын өрийн баталгаа гаргах, хувийн хэвшлийн компаниудад дэмжлэг үзүүлэх байдлаар Монгол Улсын эдийн засгийн урт хугацааны зорилтыг хангаж, болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг бууруулах.
- Засгийн газрын өрийн удирдлагын ил тод байдлыг сайжруулна

ХҮСНЭГТ 20. Макро эдийн засаг болон улсын төсвийн үзүүлэлтүүд

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨСӨӨЛӨЛ	х/нэгж	2022 I-VI*	2022 ХБГ**
ДНБ, оны үнээр	их наяд төгрөг	12.8	46.5
Эдийн засгийн өсөлт	хувь	1.9	2.6
Инфляц	хувь	16.1	8
Гадаад худалдааны нийт эргэлт	тэрбум ам.доллар	9.3	16.8
Нийт экспорт	тэрбум ам.доллар	5.3	9
Нийт импорт	тэрбум ам.доллар	3.9	7.8
Гадаад худалдааны тэнцэл	тэрбум ам.доллар	1.4	1.2
УЛСЫН ТӨСВИЙН ТӨСӨӨЛӨЛ	х/нэгж	2022 I-VI*	2022 ХБГ**
Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого	их наяд төгрөг	7.3	15.5
Нэгдсэн төсвийн нийт зарлага	их наяд төгрөг	8.1	17.9
Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл	их наяд төгрөг	-0.8	-2.3
ДНБ-д эзлэх хувь	хувь	-8.3	-5.1
ЗГ-н өрийн нийт хэмжээ	их наяд төгрөг	28.5	35.6
ДНБ-д эзлэх хувь	хувь	50.8	61.8

* Гүйцэтгэл

**Хүлээгдэж буй гүйцэтгэл

Веб хуудас: www.mof.gov.mn

Хаяг: Монгол Улсын Сангийн яам, С.Данзангийн гудамж, Засгийн газрын II байр
Д корпус, Улаанбаатар 15160, Монгол Улс